



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,  
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,  
Улаанбаатар хот, 13381

Утас/Факс: (976-51) 26 00 62

Цахим шуудан: info@spa.gov.mn

Цахим хуудас: www.spa.gov.mn

2024. 12. 16 № А-1/4594

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тендер шалгаруулалтын баримт  
бичигт өөрчлөлт оруулах тухай**

Тус газраас зарласан ЗТХЯ/20240103135 дугаартай "Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 15.6км /Говь-Алтай, Есөнбулаг сум/-ын ажлын захиалагчийн хяналтын зөвлөх сонгох" төсөл, арга хэмжээний тендерт оролцохыг сонирхогч этгээдээс тодруулга авах хүсэлт ирүүлсэнтэй холбогдуулан дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

Сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулга	Тодруулгын хариу
<p>Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 15.6 км /Говь-Алтай, Есөнбулаг сум/-ын ажлын захиалагчийн хяналтын зөвлөх үйлчилгээний ажлын нийт төсөвт өртөг 238,775,981.00 (хоёр зуун гучин найман сая долоон зуун далан таван мянга есөн зуун наян нэг) төгрөг байгаа нь зөвлөхийн зардлыг нормд зааснаар тооцоогүй захиалагчийн хяналтын зардлаар тооцож тендер зарласан байна.</p> <p>Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм ЗЗБНБД 81-013-2019-н 5.4.4. Авто замын барилга, их засварын ажлын техник, технологийн хяналтын (зөвлөх үйлчилгээ) зардлыг төсвийн шууд зардлын дүнгээс 4-5 хувиар тооцно гэж заасан байдаг.</p> <p>Иймд зөвлөх үйлчилгээний зардал нэмэгдэх боломжтой эсэхэд хариу өгнө үү.</p>	<p>Тухайн төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 2021 онд боловсруулж, 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр магадлалын дүгнэлтээр баталгаажуулсан зураг, төсвийг үндэслэн баталсан тул Зам, тээврийн хөгжлийн сайдын /хуучнаар/ 2022 оны А/20 дугаар тушаалаар баталсан "Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм /ЗЗБНБД 81-013-2019/-ын 5.4.5, 5.4.6-д заасны дагуу захиалагчийн хяналтын зардал тооцож төсөв батлаагүй тул зөвлөх үйлчилгээний зардал нэмэх боломжгүй байна.</p>

Зам, тээврийн яамнаас ирүүлсэн тодруулгын хариу, холбогдох баримт бичгийг хавсралтаар хүргүүлэв.

Тодруулга гарсантай холбогдуулан тендер шалгаруулалтын баримт бичигт дараах өөрчлөлтийг оруулж байна. Үүнд:

132462011986

1.ТШЗ 26.1.-д Тендер хүлээн авах эцсийн хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 12.00 цагт.

2.ТШЗ 26.2.-д Тендерийн нээлт хийх огноо цаг нь: 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 12.10 цагт.

ДАРГА



Ц.БАТЗУЛ